



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

“Ахмадаа сонсьё” арга хэмжээ зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргээс 2026 оныг “Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүртээмжийг сайжруулах, иргэдийн санал бодлыг сонсож бодлого шийдвэрт тусгах зорилгоор “Ахмадаа сонсьё” арга хэмжээг 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсугай.

2.Тус арга хэмжээний хүрээнд харьяалах аж ахуйн нэгж, байгууллагагүй ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3.Хүндэтгэл үзүүлэх ахмад настнуудын нэрсийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 5,465,500 (Таван сая дөрвөн зуун жаран таван мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Санжийжамц)-т зөвшөөрсүгэй.

5.Арга хэмжээг чанар, үр дүнтэй зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД